



Г МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД

## МОНГОЛЫН ГИМНАСТИКИЙН ХОЛБОО

Монгол Улс, Улаанбаатар-14191, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу-55, Спорт цогцолбор, Гимнастикийн төв  
Утас: 976-99995158, Факс: 976-77223336  
Э-шуудан: mglgym@gmail.com  
Вэб: www.gymnastics.mn

2021.04.09 № 1/017

танай \_\_\_\_\_ -ны \_\_\_\_\_ -т

Г Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан иргэдийн звлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангах, иргэний нийгмийн хөгжлийг дэмжих, холбооны эрх зүйн байдал, үйл ажиллагаатай холбоотой “Холбооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн төслийн шинэчилсэн найруулгад олон нийтээр хэлэлцүүлж санал авч байгаа билээ.

Энэхүү ажлын хүрээнд Монголын гимнастикийн холбооны зүгээс дараах саналыг хүргүүлж байна:

1. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төрийн бус байгууллагын тухай хуулийг сайжруулсан гэж үзэж байна. Ялангуяа Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцоор дагаж мөрдөх үүргийг тусгаж өгснөөрөө дэвшил болсныг уламжлах нь зүйтэй юм. Допингийн асуудлыг хамруулахад дагаж мөрдөх хөшүүрэг болох.
2. Хуулийн төсөлд “Биеийн тамир”, “Нийтийн биеийн тамир”, “Спорт”, “Спортын холбоо”-дын талаар маш учир дутагдалтай орсон байна. Тодруулбал 35.2, 35.2.1-35.2.16 дугаар заалтуудад “Биеийн тамир”, “Нийтийн биеийн тамир”, “Спорт”, “Спортын холбоо”-д гэсэн тус тусдаа, өөрсдийн ухагдахуунтай 4 салбар ойлголтыг орхигдуулжээ.
3. 38.3.4-т сонирхогчийн спорт гэж оруулсан нь явцуу, өрөөсгөл ойлголт тул тодорхой зааж өгөх хэрэгтэй. Мэргэжлийн болон сонирхогчийн спортын төрлүүдийг тодорхой зааж өгснөөр хөгжих гол суурь нь болно.
4. Энэхүү хуульд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж чадаагүй асуудлыг давхар оруулж өгснөөрөө энэ хуулийн хэрэгжилт, оршин тогтох үндэс нь болно. Жишээ нь: Гаднын мэргэжилтэн багш-дасгалжуулагч нарыг

урьж ажиллуулахад маш хүндрэлтэй байдаг холбогдох зөвшөөрлийг авахад хөнгөлөлттэй байх зарчмыг тусгах, ингэснээрээ эрүүл мэнд, боловсрол, бие бялдрын боловсрол, биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааг дэмжиж төрийн үүрэх ачааг багасгах сайн талтай.

Монголын гимнастикийн холбооноос дээрх саналуудыг албан ёсоор хүргүүлж байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд ЗГТА - Биеийн Тамир, Спортын Улсын Хороо, Спортын холбоодтой хамтарсан цахим хэлэлцүүлгийг хийх боломжтой байгааг хүлээн авна уу.

Холбоо барих утас: 99995158

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ НАРИИН  
БИЧГИЙН ДАРГА



Г. ЕРӨӨЛБАТ